



ПАКИСТАН ДАХЬ СУРАГГУЙ АЛГА БОЛГОХ ЯВДАЛ

Хэрэв хэн нэгэн үхвэл чи үйлж, хүмүүс чамайг тайвшруулах болно. Харин хэн нэгэн сураггүй алга болвол чи амьсгалж ч чадахгүй. Энэ бол гашуун гуниг билээ.

Сураггүй алга болсон Масуд Ахмад Жанжуугийн эхнэр Амина Масуд Жанжуа.

2001 оны сүүлчээс эхлэн Пакистаны засгийн газар терроризмын эсрэг дайн нэрийн дор олон хүмүүсийг улс төрийн хэрэгтэн болгохын сацуу гадаадын үндэстнүүдийг сэжиглэн баривчилж, сураггүй алга болгож байна. Масуд Ахмад Жанжуа нь Равалпиндийн бизнес эрхлэгч бөгөөд Пешавараас Лохорын 25 настай инженер Фалсал Фаразтай аялж яваад алга болжээ. Тэдний төрөл төрөгсөд Пакистаны хорих байруудад эрүү шүүлтэнд өртөж байх вий хэмээн эмээн 2006 оны 10 дугаар сард Дээд шүүхэд өргөдөл гаргасан боловч амжилт олоогүй юм. Учир нь 2007 оны 11 дүгээр сард ерөнхийлөгч Первез Мушараф онц байдал зарлаж, сураггүй алга болгосон хэрэг дээр ажиллаж байсан Пакистаны дээд шүүхийн шүүгчдийг хууль бусаар халж, хэргийг хаажээ. Энэ үеэс хойш сураггүй алга болгохтой холбоотой хэргүүд дээд шүүх дээр хүлээгдэж байна.

Эмнести Интернэшнлээс саяхан гаргасан “Пакистан дахь сураггүй алга болголт” илтгэл нь Пакистаны эрх баригчид хохирогчид болон гэрчүүдийн мэдүүлэг, шүүхийн шийдвэрийг үл харгалзан, сураггүй алга болгосон хэрэгт хариуцлага тооцох явдалыг эсэргүүцэхийн зэрэгцээ, шүүх уг хэргийг шийдвэрлэхэд нь саад учруулж байна.

2008 оны 8 дугаар сарын сонгуулийн дараа шинэ эвслийн засгийн газар байгуулагдсан байна. Пакистаны энэ шинэ засгийн газраас сураггүй алга болгох хэргийг шалгах, гэм буруутай этгээдүүдэд хариуцлага тооцохыг Эмнести Интернэшнл уриалж байгаа юм. Шинэ засгийн газар шүүгчдийг эргэн томилж, сураггүй алга бологсдын хэргийг шийдвэрлэн, хохирогчдыг цагаатгах ёстой.



2006 оны 9 дүгээр сар, Пакистаны дээд шүүхийн өмнө сураггүй алга болгох явдлыг эсэргүүцсэн жагсаал болж буй нь



Аюулгүйн албаныхан 2008 оны 2 дугаар сард болсон жагсаалыг хүч хэрэглэн тарааж буй нь. Амьдралын өртөг нэмэгдэж, цалин бага байгааг эсэргүүцсэн жагсагчдаас 100 гаруй хүн амьсгаа алджээ.

КАМЕРУНД ХОРИГДЛУУД АМИА АЛДЖЭЭ

Камеруны Дуала дах Нью Беллийн шоронгоос 6 дугаар сарын 29, 30-нд 17 хоригдол оргохыг завдаж байгаад хянагч нарын гарт амь үрэгджээ. Мөн 8 дугаар сарын 5-нд Малай гаралтай хоригдол оргохыг оролдон буудуулж нас баржээ.

Энэ нь хүч хэтрүүлэн хэрэглэж буй хамгийн сүүлийн үеийн баримт бөгөөд эрх баригчдын бодлоготой холбоотой юм. Камерун дахь хүний эрхийн хамгаалагчид болон хэвлэл мэдээллийнхний үзэж байгаагаар 6 дугаар сард болсон үйл явдлаас өмнө тус шоронд ийм хандлага ажиглагдаж байжээ.

Оргох гэж байгааг шоронгийн эрх баригчдын хувьд өмнө нь мэдсэн байсан бөгөөд урьдчилан сэргийлэх арга хэмжээ аваагүй байна. 6 дугаар сарын 29-ны үд гэхэд хоригдлууд шоронгоос хүчээр гарахыг завдахад хянагчид болон аюулгүйн албаныхан 15 хүнийг буудсан аж. Харин 30-нд 2 хүнийг буудсан байна. Мөн энгийн нэг иргэнийг хууль бусаар хөнөөжээ. Олон хоригдол болон энгийн иргэн амиа алдсан хэргийг үл харгалзан 2008 оны 7 дугаар сарын 1-нд Хууль Зүйн төвийн нарийн бичгийн дарга шоронгийн удирдлагын авсан арга хэмжээг сайшааж байгаагаа илэрхийлжээ.

Камерунд энэ мэт хүч хэтрүүлэх явдал гарсаар байна. 2007 оны 6 дугаар сард Адомогийн Иоко

шоронгоос 17 хоригдол мөн оргох гэж байгаад буудуулжээ. Гэвч эдгээр аллагыг мөрдөн шалгасан зүйл байхгүйн зэрэгцээ хэнд ч хуулийн дагуу хариуцлага ногдуулаагүй байна. 2008 оны 2 дугаар сард бослогод оролцож байгаад 100 орчим хүн алагдсан байна. Энэ бослого нь цалин бага, амьдрах өртөг өндөрсөж байгаагаар холбоотой бөгөөд Үндсэн хуульд нэмэлт оруулах гэсэн Засгийн Газрын төлөвлөгөөг эсэргүүцсэнээс үүджээ.

Эмнести Интернэшнлд ирсэн зурган баримтуудаас хоригдлуудын заримыг буудалгүйгээр баривчилж болох боломж байсныг олж тогтоогоод байна.

Камерун дахь шорон, хорих байрууд маш муу, хоригдлууд хүнд хэцүү нөхцөлд амьдарч байна. Нью Бем шорон нь 700 хүнд зориулагдан баригдсан боловч одоо 4000 орчим хоригдолтой, өвчний тархалт их байна. 8 дугаар сарын 20-нд 9 хоригдол галд түлэгдэж амь алджээ. Тус оронд хүчирхийлэл болон зүй бус харьцаа, хүчингийн хэрэг, биеэ үнэлэх явдал газар авчээ. Иймээс маш олон бослого, оргох явдал гарах болж үүнд боловсрол нимгэн, цалин багатай шоронгийн хянагч нар хүч хэтрүүлэхийг урьтал болгож байна.

ЭРИТЕР РҮҮ БУЦААГДАХ АЙДАС



Эритерийн орогнол эрэгсэд Египетэд хууль бусаар нэвтэрсэн хэмээн буруутгагдан Эритер рүү буцаагдахын өмнө Даравийн шүүх. Асвааний хойг, 2008 оны 4 дүгээр сарын 13.

Египет, Ливид хоригдож буй орогнол эрэгсэд Эритер рүү буцаагдах айдсын дор төдийгүй эрүү шүүлт, хүний эрхийн ноцтой зөрчилд өртөж байж болзошгүй байна.

2008 оны 6 дүгээр сард 1200 орчим Эритеричүүдийг Египетээс гаргасны дараа зуу зуун орогнол эрэгсэд хүчээр буцаагдах вий гэсэн айдастай байна. Мөн Ливид байгаа мянган Эритеричүүд бас л ийм зовлон эдэлдэг. Хамгийн гол нь тэд нутагтаа хөл тавих үедээ цэргийн үүргээс зугтан эх орноосоо урвасан хэрэгт баривчлагдан, эрүү шүүлтэд өртөх аюултай юм. Тэднийг шүүх ажиллагаа явуулалгүйгээр баривчилан нууц хорих байранд хорьж болзошгүй байна.

2008 оны 6 дугаар сарын 12-19-нд Египетэд урт, богино хугацаагаар хоригдож байсан 1200 орогнол эрэгчийг Эритерт буцаажээ. Египет дахь НҮБ-ын Дүрвэгсдийн Дээд Комиссарын төлөөлөгчтэй холбогдох боломж олголгүй, олон улсын өмнө хүлээсэн үүргээ умартан эрх баригчид орогнол эрэгсдийг буцааж байна.

Эритерээс ирж буй мэдээллээр ихэнх

хүмүүсийг Вай нэртэй алс бөглүү цэргийн баазад баривчилан хорьж байгаа мэдээлэл байна. Мөн жирэмсэн болон хүүхэдтэй эмэгтэйчүүдийг хорих байранд хэдэн 7 хоногээр хорьсны дараа сулласан мэдээ байна.

Эмнести Интернэшнл болон бусад байгууллагын хүчээр буцаахыг хориглох шаардлагын дараа 6 дугаар сарын 15-нд Египет дэх НҮБ-ын Хүний Эрхийн Дээд Комиссар бүх орны орогнол эрэгсэд анхаарал хандуулна гэдгээ зарлажээ.

Гэвч НҮБ-ын Хүний Эрхийн Комиссар зөвхөн Эритерийн болон Этиопын 179 иргэнийг хүлээн авчээ. Тэдгээр хүмүүс Асвальт Шалал төвийн аюулгүйн хүчний байр болон Египетийн өмнөд хэсэгт хоригдож байв. Тэдний өргөдлийг одоо Египетийн эрх баригчид

хэлэлцэж байна. 700 Эритер иргэд Мистарагийн хорих байранд буюу Триполиос 200 км-ийн алсад хоригдож байна. 6 дугаар сарын 21-нд Ливийн эрх баригчид 230 хүнийг Эритерт буцааж байгаа мэдээ Эмнести Интернэшнл авав.

Ливийн эрх баригчид Триполи дахь НҮБ-ын Хүний Эрхийн Дээд Комиссараас хоол, эмнэлгийн тусламж үзүүлэхийг зөвшөөрчээ. Тэнд одоо хоригдлуудын хамт 30 орчим хүүхдүүд хүнлэг бүх нөхцөлд амьдарч байна.

Дэлгэрэнгүй мэдээллийг доорх хаягаар авна уу. MDE 12/014(2008) and Libya: Amnesty international warns against deportation of Eritreans (MDE 19/007/2008). Эмнести Интернэшнл Эритеричүүдийг албадан буцаахыг эсэргүүцэж байна.

Р.Каражичийг баривчилсан нь шударга ёсонд хүрэх нэг алхам боллоо

12 жилийн дараа буюу 7 дугаар сарын 21-нд Боснийн Сербийн тэргүүн асан Радовин Каражичийг баривчилсан явдлыг Эмнести Интернэшнл сайшаалаа. Түүнийг геноцид, хүмүүнлэгийн эсрэг гэмт хэрэг, дайны гэмт хэрэгт буруутгаж Гаага дахь хуучин Югославын олон улсын цэргийн шүүхээр шүүж байна. Радовин Каражичийн геноцидын хэрэгт 1995 оны Сребеникийн болон Боснийн муслим шашинт 8000 орчим хүнийг алсан хэрэг хамаарч байгаа юм. Түүний тушаалын дагуу Боснийн Герцоговинд Серб бус хүмүүсийг ихээр хөнөөж, олон мянган иргэдийг хорьж, нууц хорих байрууд руу зөвөөрлөн, эрүү шүүлт тулгаж, зовоон тарчлааж байжээ. Мөн түүнийг Сараевод амь үрэгдсэн олон мянган энгийн иргэдийн хэрэгт буруутгаж байгаа юм.

Олон улсын шүүхэд эх сурвалж, баримтыг өгөх, хуучин Югослав дах мөргөлдөөний үеэрх гэмт хэргийн бүх хохирогчдын эрх ашгийг хамгаалахад хангалттай цаг хугацаа олгохыг Эмнести Интернэшнл НҮБ-д хандан уриаллаа. Ялангуяа 2010 онд дуусгасан байх хугацаа нь Ратко Младик, Горан Нажичийн дайны хэргийг авч үзэхэд хэт богино хугацаа билээ.



Нидерландын Гаага дахь Олон Улсын Зүүгийн Шүүх

АЛЖИР

Хүний эрхийн өмгөөлөгч шийтгэгджээ

Терроризмийн хэрэгт буруутгагдаж буй хүмүүсийг шударга бусаар шүүх, эрүү шүүхийг эсэргүүцэн ажиллагаараа Алжирийн хүний эрхийн хуульч Эмине Сидум нэрд гарсан юм. Тэрээр Алжир дахь «сураггүй алга бологсдын» гэр бүлийнхний төлөө ажилладаг. Гэвч энэ үйл ажиллагаа нь Алжирийн эрх баригчдын дургүйцлийг төрүүлсэн аж.

2008 оны 4 дүгээр сард Эмине Сидумыг шүүх ёсыг «уламдаа гишгэсэн» хэмээн буруутгаж 6 сар хорих, мөн 20000 динар буюу 300 доллараар торгох болжээ. Энэ нь 2004 онд өөрийнх нь үйлчлүүлэгч шүүхийн ямар ч тогтоолгүйгээр 30 сар хоригдсоныг эсэргүүцэн бичсэн тэй холбоотой байв. Эмине Сидум энэхүү явдлыг «үндэслэлгүйгээр баривчилсан хэрэг» гэж үзэж байна. НҮБ-ын Хүний Эрхийн Хороо нь Алжирт хүний эрхийн идэвхитнүүдэд дарамт шахалт үзүүлж

байгааг анхааралдаа аваад байна.

Эмнести Интернэшнл Эмине Сидумын энэ хэргийг улс төрийн зорилгоор хийгдсэн бөгөөд хүний эрхийг хамгаалах үйл ажиллагааг нь зогсоох гэсэн оролдлого гэж үзэж байна. Энэ бол Алжирт хүний эрхийн төлөө тэмцэгчид дарамт шахалтан доор байгаагийн тод илрэл юм.

Эмине Сидумын алын талаарх бодлоо илэрхийлж захидал бичнэ үү. Хүний эрхийг хамгаалагчид Хүний Эрхийн Түгээмэл Тунхаглалын дагуу үйл ажиллагаа явуулахыг нь дэмжиж ерөнхийлөгч ямар алхам хийж байгааг нь асуун дараах хаягаар захидал бичнэ үү. Abdelaziz Bouteflika President de la Republique EL Mouradia, Alger, Algeria Fax: 21321609618 E.mail: president@el-mouradia.dz



ГВЕТАМАЛ

Хүний эрхийн хамгаалагчийг заналхийлэв

Антропологич Фредди Пекерелл болон түүний гэр бүл, хамтран ажиллагсад нь хүний эрхийн төлөө ажилласныхаа төлөө амь насаа алдах аюулд байна.

Тэрбээр Гветамалын Антропологийн сангийн тэргүүн бөгөөд 1960-1996 онд дотоодын зэвсэгт мөргөлдөөний талаар судалж байсан юм. Түүний тэргүүлдэг энэ байгууллага Гветамалын хуучин цэргийн засгийн газрын үйлдсэн хүний эрхийн ноцтой зөрчлүүдийн эсрэг үйл ажиллагааг дэмжиж ажилласан бөгөөд өдгөө янз бүрийн дарамт шахалттай тулгараад байна.

Тухайлбал 2008 оны 5 дугаар сарын 19-нд тус байгууллагын тэргүүлэгч 4 гишүүнийг алахаар заналхийлсэн цахим шуудан Фредди Пекерелл болон түүний эгчид иржээ. Тэнд нь «Чиний үхэх өдөр удахгүй ирнэ. Бусдад чинь ч мөн адил. Хэн ч энэ хэргийг шалгаж чадахгүй» гэсэн байжээ. Тэд одоогоор цагдаагийн хамгаалалт байгаа ч энэ нь хангалтгүй

байна.

Эмнести Интернэшнл нь 2008 оны 12 дүгээр сарын 9-нд буюу НҮБ-ын хүний эрхийн хамгаалагчдын тухай тунхагийн 10 жилийн ойг тохиолдуулан үг хэрэгт анхаарлаа хандуулаад байна. Энэ бол Хүний Эрхийн Түгээмэл Тунхаглалын 60 жилийн ойг өмнө болж буй хэрэг юм.

Энэ заналхийлэлд даруй мөрдөн шалгалт явуулж буруутанд хариуцлага тооцохыг уриалан захидал бичнэ үү. Мөн Хүний эрхийг хамгаалагчдыг үйл ажиллагаа явуулахад нь ямар нэг хориг тавих, айдас төрүүлэхгүй байх ёстойг эрх баригчдад сануулна уу. Sr Francisco Jose Jimenez Irungaray Ministro de Gobenacion 6a. Avenida 13-718 Zona 1 (Palacio PNC) Ciudad de Guatemala, Guatemala Fax: +50224138658 Salutation: Dear Minister





Эмнести интернэшнлийн гишүүд хүчирхийллийн эсрэг кампанит ажлаа эхлүүлж буй нь, 2008 оны 6 дугаар сар. ©Amnesty International

Венесуэл дэх гэр бүлийн хүчирхийллийг таслан зогсооё

Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэлтэй тэмцэх хууль гарсан нь гайхамшигтай явдал хэдий ч Венесуэл дэх гэр бүлийн хүчирхийлэл томоохон асуудал хэвээр байна. 2007 оны эмэгтэйчүүд хүчирхийллээс ангид амьдрах эрхийг баталгаажуулсан хууль эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийг хүний эрхийн зөрчил хэмээн тодорхойлж, зөрчсөн тохиолдолд зохих хариуцлага оногдуулахыг тусгаж өгсөнөөрөө томоохон дэвшил авчирсан юм.

Түүнчлэн энэ хууль эмэгтэйчүүдийг болзошгүй хүчирхийлэлд өртөхөөс сэргийлэх, хохирогчийг хамгаалах хэм хэмжээг тогтоож өгсөн юм.

2008 оны 7 дугаар сард Эмнести Интернэшнл нь хуулинд тусгагдсан амлалт болон Венесуэл дэх эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэл хоёрын хооронд дахь зөрөөг судалсан тайлан хэвлүүлсэн билээ.

Энэ тайланд өөрсдийн туулсан амьдрал гэр бүлийн хүчирхийллийн талаар ярилцсан эмэгтэйчүүдийн яриа багтсан юм.

2007 он 7 дугаар сард Эмнести

«Бидний туулсан амьдрал тоглоом байгаагүй, амь нас минь үргэлж хутганы ирэн дээр байсан тул бид шударга ёсыг шаардаж байна. Яагаад гэвэл бид хүчирхийлэл, айдсаас ангид байх эрхтэй.» ЭИ-д ярилцлага өгсөн эмэгтэй, Венесуэл, 2007 оны 7 дугаар сар.

Интернэшнлд ярилцлага өгсөн нэгэн Венесуэл эмэгтэй: «Би хүчиндүүлсэн гэж хэлэхээсээ ичдэггүй яагаад гэвэл энэ миний буруу биш. Хүчиндүүлсэн эмэгтэйчүүд өөрөө өөрийгөө болон бусад хүмүүс түүнийг буруутгах ёсгүй гэдгийг хамгийн түрүүнд мэдэх ёстой. Надад тохиолдсон зүйл охидод минь тохиолдохыг хүсэхгүй байгаа тул би дуугүй болохгүй.» гэв.

«Хууль нь энд байна, бүгдээрээ хэрэгжүүлбэл Венесуэл дэх гэр бүлийн хүчирхийллийг таслан зогсооё» тайлангаа Эмнести Интернэшнл нийслэл Каракас болон өөр хэд хэдэн бүсүүдэд танилцуулсан бөгөөд гэр бүл дэх хүчирхийллийн талаарх уулзалт, сургалт семинарууд өдөр тутмын сонин хэвлэл, зурагт радиогийнхны

анхаарлыг татаад зогсохгүй, улс төрийн хүрээнийхэнийг ч өргөнөөр оролцуулсан байна.

Ард түмний хөдөлгөөн, Засгийн газрын хариу үйлдэл нь гайхалтай зэрэг байсан бөгөөд энэ нь Эмнести Интернэшнлийн ажиллагаа үр нөлөөгөө үзүүлсний илрэл юм.

Хүчирхийллээс хүүхэдтэйгээ хамт зугатсан эмэгтэйчүүдэд хоргодох газар хүрэлцэхгүй байгаа, эрх баригчид хэргийг тусгай шүүх байгуулах, шүүх болон цагдаагийн албан хаагчдад сургалт явуулах амлалтандаа хүрэхгүй байгааг уг тайланд онцлон тэмдэглэсэн байна. Эдгээр алхамуудыг яаралтай авч хэрэгжүүлэх нь гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн эмэгтэйчүүдэд томоохон хамгаалал болно. Энэ хууль цаасан дээрх тунхаглал төдийн зүйл хэвээр байх аваас «Хууль энэ байна. Үүнийгээ хэрэгжүүлээч» гэсэн шахалт шаардлагатай эрх баригчид тулгарах болно.

Дэлгэрэнгүй мэдээллийг, 'The law is there, let's use it' - Ending domestic violence in Venezuela (Index: AMR 53/001/2008)-аас үзнэ үү.

Мексик: ДОХ ба хүний эрх

Мексик хотноо энэ оны 8 дугаар сарын 2-8-ны хооронд болсон XVII дугаар Олон Улсын ДОХ-ын эсрэг чуулганд 2500-гаад төлөөлөгч оролцсон бөгөөд уулзалтаар ХДХВ болон ДОХ-ыг бүхий л талаас нь, үүнд хүний эрхийн болон нийгмийн асуудлуудын талаар хүртэл хэлэлцэв. Уулзалтын үеэр Нээлттэй нийгэм хүрээлэн болон Канадын ХДХВ, ДОХ-ын талаархи Хуулийн Сүлжээ ярилцлага хийх, жагсаал зохион байгуулах, уриалга гаргах зэрэг хүний эрхийн төлөөх олон ажлуудыг хамтран явуулав. Алдартай хүмүүс үгээ хэлсэн уг чуулган дээр Эмнести Интернэшнл ДОХ-ын асуудлыг хүний эрхийн асуудалтай нь хамт авч үзэж байхыг уриалав.

Судан: Үзэл санааны хоригдол асан талархал илэрхийлэв

Суданы Яруу найрагч Мажуб Шариф хоригдсон талаархи хэргийг 1990 оны 12 дугаар сард Эмнести Интернэшнл анхааралдаа авсан юм. Түүнд ил захидал ирэх хүртэл эхнэртэй нь уулзуулдаггүй байв. Тэрээр айрлолцоогоор 2000 гаруй ил захидал хүлээн авсан бөгөөд үүнийгээ бусад хоригдлуудтай хуваалцан ханан дээрээ өлгөн өрөөгөө чимдэг байжээ. Ихэнхи захидал дээр «Та Мартагдаагүй» гэж бичсэн аж.

Мажуб Шариф захидлуудаа Суданы Аюулгүйн албаны 11 удаагийн шалгалтаас нуун авч гарч чадсан бөгөөд суллагдчихаад 2008 оны 8 дугаар сард Лондонд ирснийхээ дараа хэдийгээр 17 жил өнгөрсөн ч захидал бичигчдэд талархал илэрхийлж цайллаганд урьжээ. Захиа бичигчдээс 2 нь цайллаганд найзуудтайгаа ирсэн бөгөөд олон хүмүүс түүнээс хариу сонссондоо баяртай байгаагаа илэрхийлэн захидал бичсэн байв.

Үзэл санааны хоригдол асан яруу найрагч Мажуб Шариф.

САУДЫН АРАБ

Саудын Араб: Цаазлагдах аюулд буй цагаач ажилтан

Сити Зайнаб Бинти Дури Рупа нь Мэдина шоронд 1999 оноос хойш хоригдож байна. Хоёр хүүхдийн эх болох Индонезын цагаач ажилтан энэ эмэгтэй ажил олгогчоо алсанаа «хүлээн зөвшөөрсөн» гэдэг хэргээр цаазлагдах ял авчээ.

Тэрнийг сэтгэл мэдрэлийн өвчтэй гэсэн байсан ч, хаалттай шүүх хурлын дараагаар цаазлах ял оноосон юм. Мөн түүнд анхан шатны шүүх болон шүүх хурлын үеэр өмгөөлөгч авах, орчуулагчаар хангахаас татгалзсан байна.

Эмнести Интернэшнл 1999 оноос хойш түүний ялыг хөнгөрүүлэх талаар кампанит ажил явуулж байгаа бөгөөд Саудын Арабын эрх баригчдад хандан НҮБ-ын Хүний Эрхийн Зөвлөлийн 2004/64-тоот тогтоолын «Сэтгэцийн эмгэгтэй хүнд цаазлах ял оноох болон гүйцэтгэхийг хориглох» гэсэнд анхааралдаа авахыг сануулсан юм. 2007 оны 11 дүгээр сард

Засгийн газар НҮБ-ын Хүний Эрхийн Зөвлөлд явуулсан мэдэгдэлдээ «Зайнаб нь ажил олгогчоо алсан хэрэгт буруутгагдаж байгаа бөгөөд ажил олгогчийнх нь хүүхэд нас биенд хүртэл түүний гүйцэтгэлийг хойшлуулсан» хэмээжээ.

Шариагийн хуульд зааснаар хохирогчийн өв залгамжлагч насанд хүрэнгүүтээ өршөөл үзүүлэн суллах, нөхөн төлбөр авах эсвэл шийтгэх эрхтэй байдаг.

Сити Зайнабын ялыг хөнгөрүүлэх, бусад хоригдлуудад цаазаар авах ял цаашид оноохгүй байхыг шаардаж захидал бичнэ үү. Түүнийг өмгөөлөгч болон орчуулагчаар хангах, шаардлагатай бол эмнэлгийн туслалцаа үзүүлэхийг шаардаж доорхи хаягаар захидал бичнэ үү.
King Abdullah Bin 'Abdul 'Aziz Al-Saud
Office of His Majesty The King
Royal Court, Riyadh
Saudi Arabia
Tel: + 966 1 488 2222
Salutation: Your Majesty

ТУРКМЕНИСТАН

Хүний эрхийн хамгаалагчид хоригдож байна

Хүний эрхийн зүтгэлтэн Огулсапар Мурадова, Аннакурбан, Сапардурди Хадзиев нар хүний эрхийн байгууллага болох Туркменистаны Хельсинкий сантай холбоотой гэсэн хэргээр 2006 оны 6 дугаар сарын 16-18-ны өдрүүдэд баригдан хоригдсон байна. Тагнуулын ажиллагаа явуулсан, улмаар Туркменистанд хувьсгал хийх гэсэн хэргээр Анакурбан Аманклучевыг баривчилсан хэмээн Үндэсний Аюулгүй Байдлын сайд мэдэгдсэнийг 2006 оны 7 дугаар сарын 19-нд үндэсний телевизээр гаргасан байна. Түүнд тулгаж буй хэргэ нь Польш болон Украйнд хүний эрхийн чиглэлээр семинар сургалтанд оролсон, ВВС болон Галакси Прессийн сэтгүүлчидтэй хамтран ажилласантай нь холбоотой юм. Анкурбан Аманкчиев, Огулсапар Мурадова болон Сапардурди Хадзиев нар 006 оны 8 дугаар сарын 25-нд 2 цаг хүрэхгүй хугацаанд үргэлжилсэн гүүх хурлын дараагаар тэдэнд «Хууль бусаар галт зэвсэг болон сүм зээмшсэн, хэрэглэсэн, зарсан» гэдэг хэргээр

6-7 жил хорих ял оноосон тул шударга бус шүүх ажиллагаа явагдсан гэж үзэж болохоор байна. 2006 оны 9 дүгээр сарын 14-нд Огулсар

Мурадовагийн гэр бүл нь түүнийг хоригдож байхдаа нас барсан, дух болон хузүүн дээр нь том том сорив байсан гэж мэдэгдсэн байна. Эмнести Интернэшнл дээрх хоригдлууд хоригдож байхдаа зүй бус харьцаа болон эрүүдэн шүүлтэд өртсөн байж магадгүй хэмээн санаа зовниж байна.

Огулсар Мурадова хоригдож байх хугацаандаа нас барсан талаар санаа зовниж байгаа талаараа болон түүний үхлийн хэрэгт хараат цаг, хөндлөнгийн бие даасан мөрдөн шалгалтыг цаг алдалгүй явуулахыг шаардаж доорхи хаягаар захидал уриалга явуулна үү. Мөн Аннакурбан Аманкчиев, Сапардурди Хадзиев нарыг ямар ч болзолгүй яаралтай суллахыг уриалж захидал уриалга бичнэ үү.
President Berdymukhammedov
Presidential Palace
744000 Ashgabat, Turkmenistan
Fax: + 993 1235 5112
Salutation: Dear President Berdymukhammedov

«Wife» өөрчлөгдөж байна

Эмнести Интернэшнлийн WIRE сонин дараагийн 2 сард гарахгүй, богино хугацаагаар завсарлага авч байна. Ирэх 12 дугаар сард Хүний Эрхийн Түгээмэл Тунхаглалын 60 жилийн ойгоор та бүхний оролцоотой олон шинэ өгүүлэл, үйл ажиллагаа, кампанит ажлуудын талаарх мэдээлэл бүхий сонингоо хүлээн авч уншаарай.

Шинэ хэвлэл нь цахим хуудас, шинэчлэгдсэн мэдээллийг агуулах болно. Даян дэлхийн өршөөл 10, 11 дүгээр саруудад үргэлжлэн гарсаар байх болно. Бүх уншигч, дэмжигч нартаа



баярлалаа.

WIRE сонин бичгийн баг, Хэвлэлийн хөтөлбөр

Ярилцлага: Иран дахь эмэгтэйчүүдийн эрхийн төлөө тэмцэгчид



Уян хатан байдал нь жинхэнэ нийгмийн хөдөлгөөнийг бий болгодог.

Хүний эрхийн хамгаалагч, эмэгтэйчүүдийн эрхийн төлөө тэмцэгч Сузан Та Масеб нь Тэгш эрхийн төлөө кампанит ажлыг үндэслэгч.

Эмэгтэйчүүдийн энэ хөдөлгөөн Ираны хүйсэд тулгуурласан хуулиудыг өөрчлөхийг оролдож байгаа юм. “Нэг сая гарын цэсэг” кампанит ажил нь Ираны нэг сая эмэгтэйчүүд тэгш эрхтэй байхыг хүсч буйг илэрхийлж байна.

А. Өнгөрөгч 2 жилд тус кампанит ажил хэр амжилт олсон бэ?

Х. Кампанит ажлаар эмэгтэйчүүдийн эрх нь үндэсний асуудал болох талаар хэлэлцүүлэг явуулсан. Засгийн газар эмэгтэйчүүдийг 2 дугаар ангилалын иргэд гэж хязгаарладаг. Өв залгамжлах эрх, полигамийг устгах, эмэгтэйчүүдэд зориулсан нөхөн төлбөр, чулуугаар цохиж алахыг эсэргүүцэх нь тус кампанит ажлын гол зорилго юм.

Шашны реформистууд, консерватив болон секуляр бүлгүүд нь эдгээр асуудлыг илүү нухацтай авч үзэж байна. Бидний хүрсэн зарим нэг амжилтаас дурдвал даатгалын компаниуд нь амь насаа алдах, шархдах тохилдолд эрчүүдийн адил нөхөн төлбөр авахад ижил түвшин тогтоосон.

А. Ямар үйл ажиллагааг явуулж байна вэ?

Х. Өргөх бичигт гарын үсэг зуруулахаас гадна, бид урлагийнхан, эрдэмтэд, улс төрийн нам, бодлого боловсруулагчид, нийгэмлэг, шашны тэргүүнүүдэд нөлөөлөхийг оролдож байна.

Орон зайн хувьд хязгаарлагдмал хэдий ч бид шинэ стратеги төлөвлөж байна.

Бидэнд цахим хуудас байгаа, бид сургалт семинар, хэвлэлийн хурлуудыг зохион байгуулдаг. Олон нийтэд хүргэхийн тулд урлагийнхантай хамтран ажилладаг. Бид саяхан гэрлэлт дэх тэгш бус байдал, полигамийг эсэргүүцсэн гудамжны жүжиг тоглосон.

А. Ямар бэрхшээлтэй тулгарч байна вэ?

Х. Үүлзалт, семинар, хэвлэлийн хурал хийхийг хориглосон. 50 орчим гишүүд маань баривчлагдсан. Тэднийг гарын үсэг цуглуулах үеэр баривчилж, албан байрыг маань эвдсэн. Биднийг улсын аюулгүй байдалд заналхийлж, төрийн эсрэг суртал нэвтрүүлсэн гэж буруутгадаг. Шүүхэд олон хэрэг хүлээгдэж, зарим нь давж заалдах эрхгүй байгаа ч бид тэмцээр л байна.

А. Бид тус кампанит ажлыг хэрхэн дэмжиж болох вэ?

Х. Эмнести Интернэшнл засгийн газраас баривчлагдан хоригдон гишүүдийг маань суллахыг шаардаж байна. Бид Эмнести Интернэшнл болон түүний гишүүдийг уг кампанит ажлаа үргэлжлүүлж, Ираны засгийн газрыг алгачлал бүхий хуулиа өөрчлөхийг уриалаасай гэж хүсэж байна.


Засгийн газрууд «зэвсгийн худалдааны гэрээ»-г байгуулахын тулд ажиллах ёстой

2008 оны 10 дугаар сард дэлхий даяарх засгийн газрууд яаралтай шийдэгдэх ёстой Зэвсгийн худалдааны хэлэлцээрт оролцоно. НҮБ-ын Ерөнхий Ассемблейгаас авсан мэдээ улс орнууд зэвсгийн худалдааны гэрээнд оролцох улс төрийн хүсэл бага байгааг харуулж байна. Зэвсгийн худалдааны гэрээг батлах нь энгийн иргэдийг довтолгоон, хууль бус ялын гүйцэтгэл, албадан нүүлгэх, төрлөөр устгах, зохион байгуулалттай хүчин, эрүү шүүлт зэрэг хүний эрхийн зөрчлөөс хамгаалахад ихээхэн тустай юм.

Ийм учраас засгийн газрын гол анхаарах цэг бол хүний эрх. Хууль бус зэвсэг зөвөөрлөлт олон улсын хүний эрхийн хууль, олон улсын хүмүүнлэгийн хуулийг ихээр зөрчдөг.

Тухайлбал Сомалид жижиг болон том оврын зэвсэг хэрэгслийг мөргөлдөөнд ихээр хэрэглэж байна. Ирак улс нэг хүнд оногдох бага оврын зэвсгийн тоогоор дэлхийд тэргүүлж буй орнуудын нэг болжээ. Өргөн хүрээг хамрах авч хяналт сул зэвсгийн импортын уршгаар Иракт хүний эрх ихээхэн зөрчигдөж байна.

Дэлхийн лидерүүд энэхүү хэлэлцээр хийх боломжийг ашиглан зэвсгийн хэрэглээ, худалдаа, зөвөөрлөлтөд анхаарал хандуулж олон улсын хэм хэмжээ болон хүний эрхийг хүндэтгэх ёстой.



Нэгэн эмэгтэй байшин нурахаас эмзэн зайдуу сууж байна нь. Хамар Билл Сомали 2007 оны 2 дугаар сарын 20

Дэлгэрэнгүйг «Blood at cross roads: Making the case for an Arms Trade treaty (ACT 30/011/2008)» аас харна уу.

ТА НЭГДЭЭЭРЭЙ- Ертөнц харж байна.

- Зэвсгийн худалдааны гэрээг дэмжих талаар засгийн газартаа захидал илгээ.

- 2008 оны 9 дүгээр сарын 13-19-ний өдрүүдэд болох «Ертөнц харж байна» үйл ажиллагаанд оролц.

- www.controlarms.org/en/games/catch-bombs цахим хуудаснаас «Зэвсгийг хяна» интернэт тоглоомыг үзэж, зэвсгийн худалдааг хянах талаар асуулга явуул.

Саудын Араб: Бахрайны 8 иргэн суллагдажээ



2008 оны 7 дугаар сард 134 өдөр хоригдсоны дараа дээрх хүмүүс гэртээ харих болжээ.

Саудын Арабт Бахрайны 8 иргэн 2008 оны 7 дугаар сарын 12-нд суллагдсан байна. Эдгээр хүмүүс Бахрайнаас Рияд, Саудын Арабт аялж байгаад 2008 оны 2 дугаар сарын 28-нд буцаж ирэхдээ аюулгүй албаныханд баривчлагджээ. Тэдний гэр бүлийнхэн хаана явж байгааг нь мэдэхгүй хэдэн 7 хоног оролцож байв. Сайд Ахмад Алави, Мэжид Эл-Газра, Мухаммад Абдулла-эл, Хассан Муман, Аббас Ахмад Иорганин, Иза Абдул, Мухаммад Хасан Али Мархун нар нь багш бөгөөд Мухаммад Мэхди Ким нь инженер юм. Тэднийг ганцаарчлан хорьж байжээ. Эмнести Интернэшнл тэднийг сулласан явдлыг талархан хүлээн авсан бөгөөд үүний зэрэгцээ Саудын Арабын эрх баригчдыг нууц хорионд буй хоригдлуудад анхаарал хандуулахыг шаардав. Эдгээр хоригдлын талаар мэдээлэл хомс байгаа бөгөөд эрүү шүүлт, зүй бус харьцаанд өртөж байж магадгүй байна. 2007 оны 7 дугаар сард Саудын Арабын Дотоод Хэргийн Яамны сайд 3000 орчим улс төрийн хэрэгт сэжиглэгдсэн ямарч шүүх ажиллагаагүйгээр, мөн 2003-2007 оны хооронд «терроризмын эсрэг дайн» нэрийн дор 9000 хүн хоригдсон гэжээ.

ТА ДЭЛХИЙН ИРГЭНИЙ ПАСПОРТ АВМААР БАЙНА УУ



Хүний Эрхийн Түгээмэл Тунхаглал батлагдаад 60 жил өнгөрсөн ч хүний эрх бүрэн хангагдаж чадахгүй байгаа тул дэлхий даяарх хүмүүсийг тэмцэлд уриалж байна.

Энэхүү паспортыг эзэмшигч нь дэлхийн иргэн бөгөөд Хүний Эрхийн Түгээмэл Тунхаглалд гарын үсэг зурна.

Ингэснээрээ хүн бүр арьсны өнгө, шашин шүтлэг, бэлгийн чиг хандлага, нас хүйс, хөгжлийн бэрхшээл, угсаа гарвалаасаа үл шалтгаалан ижил тэгш эрхтэй гэж үздэгээ баталгаажуулж буй хэрэг юм. Иймд энэ паспортыг эзэмшигч нь хүний түгээмэл, салшгүй эрхийг хамгаалагч болно.

Засгийн газартайгаа хариуцлага тооцож, амлалтаа биелүүлэхийг шаардаж, шударга ёсыг тогтоох, хүн бүр нэр төртэй байхын төлөө өөрийн эрхээ эдлэ. Дэлхий даяарх хүний эрхийг хамгаалагчдын хөдөлгөөн болох Эмнести Интернэшнл байгууллагын үзэл санааг дэмжин нэгдэж буйг дэлхийн иргэний паспорт гэрчилнэ.

Энэ нь Хүний Эрхийн Түгээмэл Тунхаглалыг түгээн дэлгэрүүлэх, түүний үнэт зүйлсийг хамгаалах, энэхүү үзэл санааг бодит болгохын тулд өөрийн чадах бүхнээ хийнэ гэсэн иргэн таны тангараг билээ. Паспортын тухай дэлгэрэнгүй мэдье гэвэл доорх хаягаар хандана уу.



Сонин хэвлэлийн захиалгад орсон тул шүүд захиалан унших боломжтой.